



НИЙСЛЭЛИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

1997 оны 02 дугаар
сарын 06-ны өдөр

№. 02

Улаанбаатар
хот

Сан байгуулах тухай

Нийслэлийн эрх зүйн байдлын тухай Монгол улсын хуулийн 4 дүгээр бүлгийн 18 дугаар зүйлийн 2 дугаар заалтыг үндэслэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Нийслэл хотын эдийн засаг, хот байгуулалт, түүний дэд бүтцийг хөгжүүлэх, хотын аж ахуйг өргөтгөж, хүн амын хангамж үйлчилгээ, нийгмийн асуудлыг сайжруулах, байгаль орчныг хамгаалах зорилго бүхий Нийслэлийг хөгжүүлэх "Улаанбаатар сан"-г байгуулж, дүрмийг нэгдүгээр хавсралтаар, "Улаанбаатар сан"-гийн хөрөнгийг зарцуулах журмыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. "Улаанбаатар сан"-гийн зорилго, ач холбогдлыг сурталчлах, санд хөрөнгө төвлөрүүлэх, түүнтэй холбоотой зохион байгуулалтын асуудлыг 1997 оны 1 дүгээр улиралд багтаан шийдвэрлэж хэрэгжүүлж ажиллахыг Нийслэлийн Засаг даргад үүрэг болгосугай.

НИЙСЛЭЛИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ДАРГА

Ц.БААСАНЖАВ

НИЙСЛЭЛИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Т.МАНАЛЖАВ

ТЭРГҮҮЛЭГЧ ГИШҮҮД

Т.БИЛЭГТ

Э.ГОМБОЖАВ

Б.НАМХАЙНЯМБУУ

С.МӨНХЖАРГАЛ

Б.БЭЛЭЙ

С.ПҮРЭВ

Ш.ТҮВДЭНДОРЖ